



**МОНГОЛ УЛС  
ОЛОН ҮЗҮҮЛЭЛТИЙН БҮЛГИЙН  
ТҮҮВЭР СУДАЛГАА *НЭМЭХ***

---

**СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ**

**2021 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН 19**

# АГУУЛГА

- ОҮБТС хөтөлбөрийн тойм
- ОҮБТС+ Санаачилга
- ОҮБТС+ Арга зүй
- ОҮБТС+ Монгол улс дахь хэрэгжилт

25

жил

118

улс

343

судалгаа



ove this map represent those having completed their data-collection activities in the field. The same applies to th  
tion by UNICEF on the legal status of any country or territory or the delimitation of any frontiers.

## ОУБТС ТОЙМ

- ОУБТС нь 1990 оны эхээр Хүүхдийн эрхийн талаар Дэлхийн дээд хэмжээний чуулганы зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор хийгдэж эхэлсэн.
- ОУБТС6 нь Тогтвортой хөгжлийн зорилтуудын өрхийн судалгаанаас гарах үзүүлэлтүүдийн 50 орчим хувийг агуулдаг бөгөөд Дэлхий нийтэд хэрэгждэг өрхийн судалгаануудаас хамгийн олон үзүүлэлтүүдийг тооцдог.
- Монгол улс нь ОУБТС-ны бүх 6 үе шатанд хамрагдсан цөөн орнуудын нэг бөгөөд үндэсний түвшинд 6, орон нутгийн түвшинд 4 судалгаа (Хөвсгөл аймаг, Налайх дүүрэг) хийгдсэн байна.

# ОУБТС+ САНААЧЛАГА

- ОУБТС+ нь үндэсний хэмжээнд төлөөлөх чадвартай, илүү давтамжтай, бодит хугацаанд мэдээлэх боломжтой компьютерийн тусламжтай утсаар ярилцлага авах (CATI) аргад тулгуурласан үргэлжилсэн өрхийн судалгааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой НҮБ-ын Хүүхдийн Сангийн ОУБТС-ны хөтөлбөрийн шинэ санаачилга юм.

- Туршилт судалгаа: Белиз (11 үе шат)
- Одоо хэрэгжиж байгаа улсууд: Монгол (3-р үе шат) болон Гүрж (2-р үе шат)
- Судалгаанд оролцохыг зөвшөөрсөн, утастай ОУБТС-ны өрхүүдээс төлөөлөх чадвартай дэд түүврийг сонгосон (Гүрж)
- Мөн бусад өрхийн судалгаа болон утасны дугаар бүхий бүртгэлүүдээс түүвэрлэх (Монгол)

# ОУБТС+ АРГА ЗҮЙ



ОУБТС+ны арга зүй нь төлөөлөх чадвартай, статистикийн хувьд найдвартай өрхийн судалгаа болон бодит хугацаанд мэдээлэх, компьютерийн тусламжтай утсаар ярилцлага авах (CATI) аргад суурилсан урт хугацаанд үргэлжлэх боломжтой ОУБТС+ны дижитал мэдээллийн сангийн тогтолцоо бий болгох чадварыг хослуулж чадсан.



Үндсэндээ өгөгдөл цуглуулах горим нь уламжлалт нүүр тулсан ярилцлагаас ялгаатай нь судалгаанд оролцогчдоос утсаар мэдээлэл цуглуулахад оршино.

# ОУБТС+ АРГА ЗҮЙ

Тодорхой давтамжтай мэдээлэл цуглуулалт – сар тутам

Өрхийн панел

Богино асуумж – 15-20 минут

Асуумжийн сэдэв болон асуултуудыг боловсруулах нь уян хатан:

- Үргэлжилсэн хугацааны мэдээлэл цуглуулах
- Тодорхой хөтөлбөрийн үзүүлэлтүүдийг цуглуулах
- Санал асуулга явуулах
- Хямралыг хянах

Хянах самбар болон зурагт хуудсаар дамжуулан бодит цаг хугацаатай ойр мэдээлэх

## ОУБТС+ ЖИШИГ ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

- Түүврийн загварт дараах зүйлс багтана:
  - Түүврийн хэмжээ – судалгаанд сонгогдох нэгжийн тоо
  - Түүврийн загвар ба сонголт – түүврийн нэгжүүдийн тархалт ямар болох, нэгжүүдийг хэрхэн сонгох
  - Тооцоолол – эх олонлогийг төлөөлөн сонгосон түүврээс эх олонлогийн талаар дүгнэлтийг хэрхэн гаргах вэ

# МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАН БА БОЛОВСРУУЛАХ




ОҮБТС+ тоон мэдээлэл цуглуулах тогтолцоо нь утасны сүлжээ болон / эсвэл интернетийн холболттой аль ч газраас ярилцлага (дуудлага) хийхэд суурилна.




Судалгаанд оролцогчтой ярилцаж байх үеэр ярилцлага авагч нь хариултыг Windows үйлдлийн систем бүхий таблет ашиглан цахим хэлбэрт зэрэг оруулдаг






# МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ БОЛОН БОЛОВСРУУЛАХ

- Мэдээлэл цуглуулах үйл явцыг тооллого, судалгаа боловсруулах систем (CSPro) дээр боловсруулсан ОУБТС+ мэдээлэл цуглуулах аппликейшнээр дамжуулан явуулдаг.
- Түүвэрлэгдсэн өрхүүдийг ОУБТС+ мэдээлэл цуглуулах аппликейшнээр дамжуулан ярилцлага авагчдад хуваарилдаг бөгөөд ярилцлага авагчид планшетаас Cisco Call center тоног төхөөрөмжийг ашиглан автоматаар дуудлага хийдэг.
- Мэдээллийн дүн шинжилгээг статистик боловсруулалтын SPSS програмыг ашиглан хийдэг




# МОНГОЛЫН УЛСЫН ОУБТС+ ТҮҮВРИЙН ХҮРЭЭ

- 2020 оны 1 дүгээр сард шинэчлэгдсэн Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүртгэлийг түүврийн хүрээгээр авсан.
- Утасны дугаарын тархалт өндөр: Нийт өрхийн 95% (хот 97%, хөдөөг 91%) утасны дугаартай.
- Улс орны өнцөг бүрийг хамруулах, үр дүнтэй түүврийн загварыг гаргах үүднээс системчилсэн санамсаргүй сонголтоор страта бүрээс түүвэрлэлт хийсэн.



## МОНГОЛ УЛСЫН ОУБТС+ ТУРШИЛТЫН СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ

- Утасны дугаарыг баталгаажуулах туршилтыг 2018 онд хийгдсэн нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны (НҮТС 2018) түүврээс сонгогдсон 200 өрх, 2020 оны Хүн амын бүртгэлээс 200 өрхөд хийв.
- 2018 оны НҮТС болон 2020 оны Хүн амын бүртгэлийн хамрагдсан байдал, хариу өгөхгүй байсан асуудлуудыг хооронд нь харьцуулж үзсэн.



# МОНГОЛ УЛСЫН ОУБТС+ ТУРШИЛТЫН СУДАЛГААНЫ ХАМРАГДАЛТ

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо, орон нутгийн Засаг дарга нар хамтран олон үе шаттай “Баталгаажуулах үйл явц” -ыг дараах байдлаар хийсэн.

- Утасны дугааргүй өрхүүд
- Идэвхгүй утасны дугаарууд
- Дуудлагад хариу өгөхгүй байгаа утасны дугаарууд
- Унтраасан утаснууд
- Өөр хаягт шилжсэн байх магадлалтай хувь хүн болон өрхүүд



# МОНГОЛ УЛСЫН ОУБТС+ ТҮҮВРИЙН ЗАГВАРЫН ОНЦЛОГ

- Үе шат бүрд хамгийн багадаа 2000 бүрэн ярилцлага авахын тулд түүврийн зорилтот тоог 2200 өрхөөр тогтоосон.
- Страта бүлэглэлтийг 4 бүсийн хот/хөдөө мөн Улаанбаатар хотыг суурилан хийсэн (9 страта)
- Системчилсэн санамсаргүй түүврийн аргаар сонголт хийгдсэн тул кластерийн нөлөө байгаагүй
- Тооцооллын домэйн: Сонгосон үзүүлэлтүүдийг үндэсний болон хот/хөдөөгөөр

# ОУБТС+ ТҮҮВРИЙН ХУВААРИЛАЛТ (ӨРХӨӨР)

<b>Бүс нутаг</b>	<b>Хот</b>	<b>Хөдөө</b>	<b>Нийт</b>
Баруун бүс	134	266	400
Хангайн бүс	162	238	400
Төвийн бүс	179	221	400
Зүүн бүс	160	240	400
Улаанбаатар	600		600
<b>Нийт</b>	<b>1,234</b>	<b>966</b>	<b>2,200</b>

# ОУБТС+ МОНГОЛ УЛС ДАХЬ ХЭРЭГЖИЛТ

## 1-р үе нь 5 шатлалтайгаар явагдсан

- 0 шатлал – Сонгогдсон 2200 өрхийн утасны дугаарт үндсэн 4 үүрэн телефоны операторуудаар ашиглалтад байгаа эсэхийг нь шалгуулж, ашиглалтад байхгүй утасны дугааруудыг хассан.
- 1 шатлал – түүвэр дэх ашиглалтад байгаа утасны дугаартай бүх өрхтэй утсаар холбогдох оролдлого хийсэн (2173 өрх)
- 2 шатлал – 1 дэх шатлалд холбогдож чадаагүй өрхүүдийн талаар орон нутгийн багийн засаг дарга нартай холбогдож, өрхийн мэдээллийг бататгасан болон/эсхүл хүчинтэй утасны дугаарыг авсан
- 3 шатлал – “Хамрагдаагүй” өрхийг хамгийн ойрын хөршийн шинжилгээгээр (KNN) орлуулж, орлуулсан өрхүүдтэй утсаар холбогдсон.
- 4 шатлал – 3 дахь шатлалд холбогдож чадаагүй өрхүүдийн талаар орон нутгийн багийн засаг дарга нартай холбогдож өрхийн мэдээллийг бататгасан болон/эсвэл хүчинтэй утасны дугаарыг авсан. Гэрийн эзэн өөрчлөгдсөн эсхүл утасны дугаар өөрчлөгдсөн өрхүүдтэй утсаар холбогдсон.

# ЗАГВАРТ СУУРИЛСАН ОРЛУУЛАЛТ

- 1-р үеийн 2 дахь шатлалын төгсгөлд 1854 өрхөөс ярилцлага авсан байсан.
- ОУБТС+ 1-р үеийн 2 дахь шатлалын төгсгөлд ярилцага аваагүй өрхүүдийг загварт суурилсан орлуулах аргачлалаар орлуулсан.
- Орлуулалтыг статистикийн програм SPSS болон “Euclidian зай” зарчимд суурилсан “хамгийн ойрын хөрш” функцийг ашиглан хийсэн. Үүний үр дүнд 344 өрхийг орлуулсан. Энэхүү загвар нь хүн амын бүртгэлээс авах боломжтой 16 хувьсагчийг ашиглан тухайн өрхүүдийн Euclidian зайг тооцож Euclidian хамгийн бага зайтай өрхийг сонгосон.



# 1-Р ҮЕИЙН ХАРИУЛТЫН ХЭВ ШИНЖ

Орлуулалтын дараах ярилцлагын үр дүн	Өрхийн тоо
Бүрэн хамрагдсан	2,126
Татгалзсан	17
Ярилцлага өгөх чадваргүй	2
Сонгогдсон өрхийн утасны дугаар биш	8
Утасны дугаар идэвхгүй	1
Ярилцлага өгөгч завгүй байсан/хойшлуулсан	3
Олон дахин залгасан боловч утсаа аваагүй	22
Сонгогдсон өрхөд утасны дугаар байгаагүй	6
Одоогоор эзгүй байгаа	15
<b>Нийт</b>	<b>2,200</b>
<b>Хамрагдалтын хувь</b>	<b>97.3</b>

- Хамралтын хувийг нэмэгдүүлэхийн тулд орлуулсан 344 өрхтэй холбогдсон
- Сонгогдсон 2200 өрхөөс 2126 өрх судалгаанд бүрэн хамрагдсан (97%)
- Зөвхөн 1-р үед орлуулах аргачлалыг хэрэглэсэн ба дараа дараагийн үеүдэд орлуулах аргачлалыг хэрэглэхээр төлөвлөөгүй.

Ярилцлагын үр дүн	Өрхийн тоо
Ярилцлагад хамрагдсан	1,987
Татгалзсан	40
Ярилцлага өгөх чадваргүй	1
Утасны дугаар идэвхгүй	3
Ярилцлага өгөгч завгүй/хойшлуулсан	16
Олон дахин залгасан боловч утсаа аваагүй	107
<b>Нийт</b>	<b>2,154</b>
<b>Хамрагдалтын хувь</b>	<b>92.2</b>

## 2-Р ҮЕИЙН ХАРИУЛТЫН ХЭВ ШИНЖ

# БАЯРЛАЛАА